

БАТЛАВ.

“БАГАНУУР ҮЙЛДВЭРЛЭЛ ТЕХНОЛОГИЙН ПАРК”
ОНӨТҮГ-ЫН ДАРГА Ч.ЭЛБЭГСАЙХАН

2019 оны 07 дугаар сарын 16 өдөр

“БАГАНУУР ҮЙЛДВЭРЛЭЛ ТЕХНОЛОГИЙН ПАРК” ОНӨТҮГ-ЫН БАЙГАЛЬ ОРЧНЫ
НӨЛӨӨЛЛИЙН НАРИЙВЧИЛСАН ҮНЭЛГЭЭ ХИЙХ АЖЛЫН ДААЛГАВАР

Дугаар 2019/01

2019 оны 07 дугаар сарын 16

Багануур дүүрэг

д/д	Ажлын нэр төрөл	Тайлбар
1	Ажил гүйцэтгэх үндэслэл	Багануур үйлдвэрлэл технологийн парк ОНӨТҮГ-ын Байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээ / БОННУ/ хийх хууль эрх зүйн үндэслэл: <ul style="list-style-type: none">• Монгол улсын үндсэн хууль• Монгол улсын хот байгуулалтын тухай хууль• Байгаль орчныг хамгаалах тухай хууль• Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хууль• Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хуультай холбогдон гарсан хууль эрх зүйн зохицуулалтууд• Газрын тухай хууль• Агаарын тухай хууль• Усны тухай хууль• Хөрс хамгаалах, төлжилтөөс сэргийлэх тухай хууль• Байгалийн ургамлын тухай хууль• Амьтны тухай хууль• Хог хаягдлын тухай хууль• Химийн хорт ба аюултай бодисын тухай хууль• Багануур үйлдвэрлэл технологийн паркийн нарийвчилсан Техник эдийн засгийн үндэслэл• Багануур үйлдвэрлэл технологийн парк байгуулах төслийн Байгаль орчны төлөв байдлын үнэлгээний тайлан• Багануур үйлдвэрлэл, технологийн паркийн эзэмшил газрын төлөв байдал, чанарын улсын хянан баталгааны ажлын тайлан
2	Ажлын зорилго, шийдвэрлэх асуудал	Зорилго: Байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээгээр Багануур үйлдвэрлэл технологийн парк байгуулах төслөөс байгаль орчинд үзүүлэх нөлөөллийг тодорхойлох, нөлөөллийг үнэлэх, сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах арга хэмжээг тодорхойлох, Шийдвэрлэх асуудал: Багануур үйлдвэрлэл технологийн парк байгуулах төсөлд Байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээг хийж, БОАЖЯ-ны мэргэжлийн зөвлөлийн хурлаар хэлэлцүүлж баталгаажуулах
3	Баримтлах зарчим	Төслийн байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээг дараах зарчимд нийцүүлэн боловсруулах: <ul style="list-style-type: none">• БОАЖЯ-ны Байгаль орчны нөлөөллийн ерөнхий үнэлгээний дүгнэлтийг мөрдөх;


		<ul style="list-style-type: none"> • Байгалийн зүй тогтол, шинжлэх ухаан, технологийн ололтод үндэслэсэн, инженерийн оновчтой шийдэл бүхий баримт бичиг байх; • Төсөл хэрэгжүүлэгч бүр байгаль орчныг хамгаалагч байх; • Газар ашиглалтын эрх зүйн зөрчил үүсэхээргүй нөхцөл бүрдүүлсэн баримт бичиг байх; • Орон нутгийн хөгжлийн төлөвлөлттэй уялдсан байх; • Төлөвлөгөө нь хэрэгжих боломжтой, хэмжих, дүгнэх шалгууртай байх.
4	Ажлын хамрах хүрээ	Багануур үйлдвэрлэл технологийн парк байгуулах нутаг дэвсгэр /Багануур дүүргийн 2,3,5 дугаар хороо/
5	Ажил гүйцэтгэх хугацаа	3 сар байна.
6	Ажлын иж бүрдэл	<p>Байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээ нь дараах бүрдэлтэй байна:</p> <ul style="list-style-type: none"> • Байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээ нь үндсэн тайлан, холбогдох баримт бичгийг бүрэн хамруулсан хавсралттай байх; • Төслийн нөлөөллийг байгаль орчны бүрдэл хэсгүүд, нийгэм, хүний эрүүл мэндийг хамруулан тодорхойлох; • Төслийн нөлөөллийн эрчим, тархалт, үр дагаврыг тооцон үнэлэх бөгөөд эдгээр нь төслийн бүрдэл хэсгүүдийн үйл ажиллагаа болон байгаль орчин, нийгэм, хүний эрүүл мэндийг бүрэн хамруулсан байх; • Төслийн барьж байгуулах, үйл ажиллагаа явуулах үе шатыг хамруулан эерэг болон сөрөг нөлөөллийг үнэлсэн байх; • Төсөлд тусгасан олон үйлдвэрүүд болон хотын төслүүдийн хуримтлагдах нөлөөллийг хамтатган өнгөрсөн, одоо, ирээдүйтэй холбон үнэлсэн байх; • Үйлдвэрүүдийн онцлогтой уялдуулан эрсдэлийн үнэлгээ хийж, эрсдэлээс урьдчилан сэргийлэх, бууруулах арга хэмжээг тодорхойлсон байх; • Төслийг сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний зөвлөмжүүдийг бүрэн хэмжээгээр боловсруулах; • Үйлдвэрлэл, технологийн парк байгуулах төслийн хүрээнд баригдах дэд бүтэц, инженерийн болон бусад барилга байгууламжийг барих төслийг хэрэгжүүлэх явцад, уг төслүүдээс байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг нарийвчилсан үнэлгээний үндсэн дээр урьдчилан тодорхойлж, сонгосон байршлуудад төслийг хэрэгжүүлэх боломжтой эсэхэд үнэлэлт дүгнэлт өгөх; • Хөрс, ус, биологийн төрөл зүйл хамгаалах төлөвлөгөө боловсруулсан байх; • Үйлдвэрлэл, технологийн паркад баригдах үйлдвэрүүд, бусад дагалдах байгууламжуудад шаардагдах ахуйн болон бусад усны хэрэглээ, ашиглалтыг урьдчилсан тооцож, түүнийг хангах гадаргын болон газрын доорх усны эх үүсвэрүүдийг өнөөгийн төлөв байдлыг судалж, ашиглах боломжит усны нөөцөд тулгуурлан үнэлэлт өгөх; • Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр боловсруулсан байх; • Хог шингэн бохирын хаягдлын менежментийн төлөвлөгөө боловсруулсан байх;

		<ul style="list-style-type: none"> • Үйлдвэрлэлийн хог хаягдал, химийн хорт бодисын хаягдлыг тооцон аюулгүй устгах арга замыг тодорхойлсон байх; • Үйлдвэр болон төслийн бүрэлдэхүүн хэсгээс ялгарах бохирдлын хэмжээ, түүний тархалт, нөлөөллийн хүрээг нарийвчлан тодорхойлж, зураглал үйлдэн тайланд хавсаргах; • Төслийн үйл ажиллагааны явцад гарах ахуйн болон үйлдвэрлэл /барилга/-ийн хог хаягдал, аюултай хог хаягдлыг хүний эрүүл мэнд, байгаль орчинд халгүй аргаар цогцоор нь цуглуулах, ангилан ялгах, дахин ашиглах, устгах, аюулгүй болгох аргыг Хог хаягдлын тухай хуульд нийцүүлэн нарийвчлан тооцож, төслийн үйл ажиллагааны салшгүй хэсэг болгон хог хаягдлыг эх үүсвэр дээр нь устгах хөтөлбөр зөвлөмж боловсруулж хэрэгжүүлэх; • Төсөл хэрэгжих нутагт амьдарч буй иргэд, дүүргийн удирдлагуудтай нягт хамтран ажиллах, төслийн үйл ажиллагааны цар хүрээ, байгаль орчинд халгүй аргаар нийгэм эдийн засаг, орон нутгийн хөгжилд үзүүлэх давуу болон сул талыг дэлгэрэнгүй танилцуулж, тэдний саналыг албан ёсоор авах; • Үйлдвэрлэл, технологийн паркийн дэд бүтцийн барилга байгууламж болон бусад үйл ажиллагаанд шаардагдах түүхий эд /элс, хайрга.г.м/ шатах тослох материалын нийлүүлэлт, хадгалалт, ашиглалтын талаар нарийвчилсан судалгаа гаргаж, эх үүсвэр бүрийг нарийвчлан тогтоох; • Төслийн үйл ажиллагаанд болон байгалийн гамшгаас үүдэн гарч болзошгүй ослын үнэлгээ хийж, ослоос сэргийлэх, түүнийг багасгах, арилгах арга хэмжээг тодорхойлж тайланд тусгах; • Үйлдвэрлэл, технологийн паркийн төслийг хэрэгжүүлэх явцад мөрдөж ажиллах Байгаль орчны менежментийн төлөвлөгөө /Байгаль орчныг хамгаалах төлөвлөгөө, орчны хяналт шинжилгээний хөтөлбөр/-г боловсруулж, түүнийг хэрэгжүүлэхэд шаардагдах хөрөнгө, зардлыг эхний 5 жилээр тооцож ирүүлэх; • Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн 10¹ –р зүйлд заасны дагуу төслийн үйл ажиллагааны хэрэгжилтэд байгаль орчны төлөвлөгөөт аудитыг төслийн 2 дахь жилээс хийлгэх, аудитын дүгнэлт зөвлөмжийг холбогдох газруудад хүргүүлэх хугацаа, зардлыг тайланд тусгах; • Нарийвчилсан үнэлгээ хийх явцад уг төсөл, БОННУ-ний ажлын тайланг төсөл хэрэгжих хороодын ИНХ-аар хэлэлцүүлж, хурлын тэмдэглэл, шийдвэр болон дүүргийн Засаг даргын /УТХ/ саналыг авч тайланд хавсаргах; • Багануур үйлдвэрлэл, технологийн паркийн төслийн хүрээнд хэрэгжих дэд төслүүдэд тухай бүр байгаль, орчны нөлөөллийн үнэлгээ хийлгэн шийдвэрлүүлж ажиллахыг зөвлөмжөөр тусгах;
7	Гүйцэтгэх ажлын үе шат	<p>Ажлыг дараах үе шатаар гүйцэтгэнэ:</p> <ul style="list-style-type: none"> • <i>Бэлтгэл ажил:</i> Төслийн баримт бичигтэй танилцах, газар дээр нь очиж тодруулга хийх, үнэлгээнд ашиглах судалгааны материал бүрдүүлэх; • БОННУ хийж, тайлан бичих;

		<ul style="list-style-type: none"> • Орон нутгийн иргэдийн санал авах, Багийн иргэдийн нийтийн хурлаар хэлэлцүүлж саналыг нь авах, шийдвэр гаргуулах; • БОННУ-ний тайланд төсөл хэрэгжүүлэгчээс санал авах; • БОННУ-ний тайланг БОАЖЯ-нд хүргүүлж, шинжээчээр шүүмж хийлгэх, шүүмжийн дагуу холбогдох засварыг хийх, • Мэргэжлийн зөвлөлийн хурлаар хэлэлцүүлж тайланг батлуулах; • Төслийн БОННУ-ний тайланг захиалагчид хүлээлгэн өгөх; • Гэрээг дүгнэх;
8	Техникийн шаардлага, заавар	<ul style="list-style-type: none"> • БОАЖЯ-ны 2019 оны 02 сарын 15-ны өдрийн 13/952 албан бичиг, түүний хавсралт Ерөнхий үнэлгээний дүгнэлт; • Засгийн газрын 2013 оны 374 дүгээр тогтоолын 2 дугаар хавсралт Байгаль орчны нөлөөллийн үнэлгээний журам; • Засгийн газрын 2003 оны 28 дугаар тогтоолоор батлагдсан Газрын төлөв байдал, чанарын улсын хянан баталгаа хийх журам; • Барилга хот байгуулалтын сайдын 2008 оны тушаалаар батлагдсан “Хиймэл дагуулын технологиор геодезийн сүлжээ байгуулах үндсэн дүрэм” БНБД14-101-03; • Бүх төрлийн дүн шинжилгээг стандарт аргачлалын дагуу хийсэн байна. • Инженер эдийн засгийн тооцооллыг математик загварчлал ашиглан боловсруулсан байна. • Заавал мөрдөх акт, нотлох баримт, тэмдэглэлийг үйлдсэн байна. • Гүйцэтгэгч байгууллага нь захиалагчид 7 хоног бүр гүйцэтгэлийг тайлагнана. • Байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага дүгнэлт, саналыг өгч, ажил шалгасан акт, ажил хүлээн авсан акт үйлдсэнээр ажлыг дууссанд тооцно.
9	Ажлын хяналт шалгалт	Захиалагч байгууллага ажлын гүйцэтгэлийн явцад тогтмол хяналт тавина.
10	Хүлээлгэн өгөх материал	Байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний иж бүрэн материалыг /үнэлгээний батлагдсан тайлан, батлагдсан байгаль орчны менежментийн төлөвлөгөө, холбогдох зураг, шинжилгээний бичгүүд, CD/ дараах байгууллагуудад тус бүр 1 хувийг хүлээлгэн өгнө. Үүнд: <ol style="list-style-type: none"> 1. БОАЖЯ 2. Төсөл хэрэгжүүлэгч - “Багануур үйлдвэрлэл технологийн парк” ОНӨТҮГ 3. Нийслэлийн Хөрөнгө Оруулалтын Газар
11	Захиалагч байгууллага	“Багануур үйлдвэрлэл технологийн парк” ОНӨТҮГ
12	Санхүүжилт эх үүсвэр	Нийслэлийн Засаг даргын 2019 оны 06 дугаар сарын 21-ний өдрийн А/619 дүгээр захирамжаар Нийслэлийн төсвийн хөрөнгөөр 2019 онд хэрэгжүүлэх хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний жагсаалтын 58.1.2-ын “7”-т тусгагдсан Шинээр баригдах барилга байгууламж, авто зам, инженерийн шугам сүлжээний зураг төсөв, хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөө, ТЭЗҮ, мастер төлөвлөгөө боловсруулах ажлын зардлаас гүйцэтгэлээр санхүүжүүлнэ.
13	Даалгаварт тусгагдаагүй ажил	Даалгаварт тусгагдаагүй ажлыг нэмэлт нөхцөлөөр гүйцэтгэнэ.

ЗӨВШӨӨРСӨН:

“БАГАНУУР ҮЙЛДВЭРЛЭЛ, ТЕХНОЛОГИЙН ПАРК” ОНӨТҮГ-ЫН
ЗАХИРГААНЫ АЛБАНЫ АХЛАХ МЭРГЭЖИЛТЭН



Б.МИЧИД-ЭРДЭНЭ

БОЛОВСРУУЛСАН:

“БАГАНУУР ҮЙЛДВЭРЛЭЛ, ТЕХНОЛОГИЙН ПАРК” ОНӨТҮГ-ЫН
ҮЙЛДВЭРЛЭЛ, ТЕХНОЛОГИЙН АЛБАНЫ ХЭСЭГЧИЛСЭН
ЕРӨНХИЙ ТӨЛӨВЛӨЛТ, ДЭД БҮТЦИЙН ИНЖЕНЕР



Б.МӨНГӨНХУЯГ

БАЙГАЛЬ ОРЧИН, АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ЯАМ

ЕРӨНХИЙ ҮНЭЛГЭЭНИЙ ГҮЙЦЭТГЭЛИЙН ХУУДАС

2019 оны 02-р сарын 13

Улаанбаатар хот

Төслийн дугаар

Дугаар 2019/J 019

Төсөл хэрэгжүүлэгчийн нэр, хаяг: “Багануур үйлдвэрлэл, технологийн парк” ОНӨААТҮГ, регистрийн дугаар: 8184062, Улаанбаатар хот, Багануур дүүрэг, 1-р хороо, Наран хороолол, ЗДТГ-ын 1 давхарт.

Төслийн нэр: Багануур үйлдвэрлэл, технолгийн парк

Төсөл хэрэгжих нутаг дэвсгэр, байршил: Улаанбаатар хотын Багануур дүүргийн 2, 3, 5 дугаар хорооны нутагт, дүүргийн Засаг даргын захирамжаар олгогдсон нийт 414 га талбайд хэрэгжинэ.

Холбоо барих утас: 976-7021-3292.

Орон нутгийн санал: Улаанбаатар хотын Багануур дүүргийн Засаг даргын 2018 оны 11 дүгээр сарын 15-ны өдрийн 01/280 тоот албан бичгээр ирүүлсэн санал болон Засгийн газрын 2016 оны 05 дугаар сарын 23-ны өдрийн 272 дугаар тогтоолыг үндэслэн Аж үйлдвэрийн Сайд /хуучин нэрээр/-ын 2016 оны 06 дугаар сарын 06-ны өдрийн “Үйлдвэрлэл, технологийн паркийн үйл ажиллагаа эрхлэх” 2016/01 дугаартай тусгай зөвшөөрлийг тус тус харгалзан үзэв.

	Ерөнхий үнэлгээний гол шалгуурууд	Нийцсэн	Бийцээгүй	Нэгдүгээр үнэлгээний шалгууртай	Нийцсэн
Байгаль орчныг хамгаалах хууль тогтоомжийн нийцэл	Монгол улсад хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа байгаль орчныг хамгаалах болон байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хууль тогтоомжийн холбогдох заалт	Тийм			Нарийвчилсан үнэлгээний явцад хууль тогтоомжийн нийцлийг нарийвчлан тодорхойлох
Төрийн бодлого, шийдвэрийн нийцэл	Төрөөс баримтлах бодлогын баримт бичиг, Стратегийн үнэлгээний дүгнэлт, зөвлөмжийн холбогдох заалт	Тийм			
Төслийн байршил, түүнтэй холбогдох шалгуурууд	Хуулиар хамгаалагдсан газар нутаг байгаа эсэх (урсац бүрэлдэх эх, ойн болон усны сан бүхий газрын хамгаалалтын бүс, хилийн хамгаалалтын бүс, орон нутгийн тусгай хамгаалалттай газар г.м) ✓			Тийм	
	Төсөл хэрэгжих нутаг дэвсгэр нь хүний нөлөө, байгаль цаг уурын өөрчлөлтөд эмзэг, мэдрэмтгий эсэх			Тийм	
	Төсөл хэрэгжих нутаг дэвсгэр, түүний ойр орчимд улс, орон нутгийн хэтийн хөгжилд ашиглахаар төлөвлөсөн, сөрө нөлөөлөлд өртөж болзошгүй газар байгаа эсэх			Тийм	
	Болзошгүй хуримтлагдах нөлөөлө үүсгэх эсэх			Тийм	

Төслийн байгаль орчны нөлөөллийн урьдчилсан үнэлгээ	Агаарын чанар			
	Бохирдуулагч болон аюултай хортой бодис агаар мандалд ялгаруулах, эсэх			Тийм
	Дуу чимээ, доргио чичиргээ гэрлийн болон дулааны нөлөөлөл, цахилгаан соронзон цацраг үүсэх, эсэх			Тийм
	Усан орчин			
	Гадаргын болон газрын доорх усны нөөцийн хомсдол үүсэх, эсэх			Тийм
	Цэнгэг усны нөөцийг ашиглах, эсэх			Тийм
	Гадаргын болон газрын доорх усанд бохирдол үүсэх, эсэх			Тийм
	Хөрсөн бүрхэвч			
	Хөрсөн бүрхэвч эвдрэх, эсэх			Тийм
	Хөрс бохирдуулах эсэх			Тийм
	Хөрс доройтох, цөлжих эсэх			Тийм
	Ургамлан нөмрөг			
	Ургамалан нөмрөг өртөх эсэх			Тийм
	Ховор, нэн ховор ургамлын төрөл зүйлс өртөх, эсэх			Тийм
	Амьтны аймаг			
	Зэрлэг амьтдын амьдрах орчинг доройтуулах, эсэх			Тийм
	Ховор, нэн ховор амьтан өртөх, эсэх			Тийм
Нийгмийн нөлөөллийн урьдчилсан үнэлгээ	Нутгийн оршин суугчид			
	Газар эзэмших, ашиглах эрх зөрчигдөх, эсэх	Тийм		
	Нутгийн оршин суугчдын нийгмийн байдалд сөрөг нөлөөлтэй, эсэх			Тийм
	Нөлөөлөлд өртөж болзошгүй төв, суурин газар байгаа, эсэх			Тийм
	Нүүлгэн шилжүүлэх асуудал үүсэх, эсэх			Тийм
	Түүх, соёлын биет өв			
	Сөрөг нөлөөлөлд өртөх түүх, соёлын үнэт зүйлс бий эсэх			Тийм
	Хүний эрүүл мэндэд нөлөөлөх нөлөөлөл			
	Нутгийн иргэд, оршин суугчдын эрүүл мэндэд сөргөөр нөлөөлөх эсэх			Тийм
	Төслийн бүх үе шатанд хүний эрүүл мэнд, амь насанд эрсдэл үүсэх эсэх			Тийм

Нэгдсэн дүгнэлт:

Улаанбаатар хотын Багануур дүүргийн 2, 3, 5 дугаар хорооны нутагт хэрэгжүүлэх “Багануур үйлдвэрлэл, технолгийн парк байгуулах төсөл”-д хийсэн Ерөнхий үнэлгээний гүйцэтгэлээр уг төсөлд холбогдох аргачлалын дагуу Байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээ хийлгэх шаардлагатай гэж үзлээ.

Онцгойлон анхаарах зүйлс:

1. Үйлдвэрлэл, технолгийн парк байгуулах төслийн хүрээнд баригдах дэд бүтэц, инженерийн болон бусад барилга байгууламжийг барих төслийг хэрэгжүүлэх явцад, уг төслүүдээс байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг нарийвчилсан үнэлгээний үндсэн дээр урьдчилан тодорхойлж, сонгоон байршилүүдэд төслийг хэрэгжүүлэх боломжтой эсэхэд үнэлэлт дүгнэлт өгөх;
2. Үйлдвэрлэл, технолгийн паркт баригдах үйлдвэрүүд, бусад дагалдах байгууламжуудад шаардагдах ахуйн болон бусад усны хэрэглээ, ашиглалтыг урьдчилан

тооцож, түүнийг хангах гадаргын болон газрын доорх усны эх үүсврийн өнөөгийн төлөв байдлыг судалж, ашиглах боломжит усны нөөцөд тулгуурлан үнэлэлт дүгнэлт өгөх.

3. Үйлдвэр болон төслийн бүрэлдэхүүн хэсгээс ялгарах бохирдлыг хэмжээ, түүний тархалт, нөлөөллийн хүрээг нарийвчлан тодорхойлж, зураглал үйлдэн тайланд хавсаргах;

4. Төслийн үйл ажиллагааны явцад гарах ахуйн болон үйлдвэрлэл/барилгын хог хаягдал, аюултай хог хаягдлыг хүний эрүүл мэнд, байгаль орчинд халгүй аргаар цогцоор нь цуглуулах, ангилан ялгах, дахин ашиглах, устгах, аюулгүй болгох аргыг Хог хаягдлын тухай хуульд нийцүүлэн нарийвчлан тооцож, төслийн үйл ажиллагааны салшгүй нэг хэсэг болгон хог хаягдлыг эх үүсвэр дээр нь устгах хөтөлбөр, зөвлөмж боловсруулж хэрэгжүүлэх;

5. Төсөл хэрэгжих нутагт амьдарч буй иргэд, дүүргийн удирдлагуудтай нягт хамтран ажиллах, төслийн үйл ажиллагааны цар хүрээ, байгаль орчинд халгүй аргаар нийгэм, эдийн засаг, орон нутгийн хөгжилд үзүүлэх давуу болон сул талыг дэлгэрэнгүй танилцуулж, тэдний саналыг албан ёсоор авах;

6. Үйлдвэрлэл, технолгийн паркийн дэд бүтцийн барилга, байгууламж болон бусад үйл ажиллагаанд шаардагдах түүхий эд /элс, хайрга г.м/, шатах тослох материалын нийлүүлэлт, хадгалалт, ашиглалтын талаар нарийвчилсан судалгаа гаргаж, эх үүсвэр бүрийг нарийвчлан тогтоох;

7. Төслийн үйл ажиллагаа болон байгалийн гамшгаас үүдэн гарч болзошгүй ослын үнэлгээ хийж, ослоос сэргийлэх, түүнийг багасгах, арилгах арга хэмжээг тодорхойлж тайланд тусгах.

8. Үйлдвэрлэл, технолгийн паркийн төслийг хэрэгжүүлэх явцад мөрдөж ажиллах Байгаль орчны менежментийн төлөвлөгөө /Байгаль орчныг хамгаалах төлөвлөгөө, орчны хяналт-шинжилгээний хөтөлбөр/-г боловсруулж, түүнийг хэрэгжүүлэхэд шаардагдах хөрөнгө, зардлыг эхний 5 жилээр тооцож ирүүлэх;

9. "Байгаль орчныг хамгаалах тухай" хуулийн 10¹-р зүйлд заасны дагуу төслийн үйл ажиллагааны хэрэгжилтэд байгаль орчны төлөвлөгөөт аудитыг төслийн 2 дахь жилээс хийлгэх, аудитын дүгнэлт зөвлөмжийг холбогдох газруудад хүргүүлэх хугацаа, зардлыг тайланд тусгах;

10. Нарийвчилсан үнэлгээ хийх явцад уг төсөл, БОННУ-ний ажлын тайланг төсөл хэрэгжих хороодын ИНХ-аар хэлэлцүүлж, хурлын тэмдэглэл, шийдвэр болон дүүргийн Засаг даргын /ИТХ/ саналыг авч тайланд хавсаргах.

11. Багануур үйлдвэрлэл, технолгийн парк байгуулах төслийн хүрээнд хэрэгжих дэд төслүүдэд тухай бүрт байгаль орчны нөлөөллийн үнэлгээ хийлгэн шийдвэрлүүлж, ажиллахыг төсөл хэрэгжүүлэгч, хамтран хэрэгжүүлэгч байгууллагууд хариуцан гүйцэтгэх;

Заавал хэрэгжүүлэх шаардлагатай дээр дурдсан арга хэмжээг цаг хугацаанд нь ханган биелүүлээгүй тохиолдолд ерөнхий үнэлгээний дүгнэлтийг хүчингүй болгож, "Зөрчлийн тухай" хуулийн 7.1 дүгээр зүйлийн 1, 2 дахь хэсэгт заасны дагуу хариуцлага тооцдог болохыг анхаарна уу.

Ерөнхий үнэлгээ хийсэн:
**БАЙГАЛЬ ОРЧИН, АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН
ЯАМНЫ ШИНЖЭЭЧ**

Д.ШИЖИР ЭРДЭНЭ

Ерөнхий үнэлгээний үр дүнг
зөвшөөрсөн:

"Багануур үйлдвэрлэл, технолгийн
парк" ОНӨААТҮГ-ын дарга

БАГАНУУР
ҮЙЛДВЭРЛЭЛ,
ТЕХНОЛОГИЙН
ПАРК
ОНӨААТҮГ-ЫН
ДАРГА
УТГМ016 810-092
7115 10106

Ч.Элбэгсайхан